




ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДҮҮДИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

АУДИТЫН КОД: ХЭА-2021/123-ШТА-ГА

"ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ЗОХИЦУУЛАЛТ, ҮР АШИГ"-Т ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хэрлэн сум 2021 он



Аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх
аудитор Ч.Эрдэнэбаатар

Утас: 70562112 Цахим хаяг: erdenebaatararch@audit.gov.mn

Аудитын менежер Д.Оюунтуяа

Утас: 92116773 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Ахлах аудитор Ч.Баярцолмон

Утас 92114113 Цахим хаяг: bayartsolmonch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА		
<u>Аудитыг гүйцэтгэсэн:</u>	Товчилсон үгийн жагсаалт	2
Хэнтий аймаг дахь Төрийн Аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй ..	3-4
Дарга, Тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар	Ерөнхий мэдээлэл	4-5
Аудитын менежер Д.Оюунтуяа	Бүлэг 1: Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийг эд хөрөнгийн эрхийн байдлаар хуульд зааснаар ангилан тодорхойлоогүй байна.	5-6
Ахлах аудитор Ч.Баярцолмон	- Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийг хуулийн дагуу ангилаагүй. - Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн үйл ажиллагааны зорилго, зорилтыг тодорхойлолгүй, гүйцэтгэх чиглэлээр ажиллах дүрмийг боловсруулан мөрдлөг болгон ажиллаж байна.	5
2021 оны 6 дугаар сарын 23-нд	Бүлэг 2: Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн зорилго, зорилтын хангалтыг бус эрхлэн гүйцэтгэх чиглэлээр үйл ажиллагааг дүгнэжээ.	6-7
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудал байвал 70562147 дугаарын утас, 70562112 дугаарын факсаар харилцана уу	- Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд хууль тогтоомж, тогтоол шийдвэр, батлагдсан дүрэм журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна. - Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн зорилго, зорилтыг үйл ажиллагааны дүрэмд тодорхойлоогүй тул хангагдан ажилласан гэж үзэх боломжгүй.	7
ХАЯГ:	Бүлэг 3: Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн үйл ажиллагааны үр ашгийг тооцож, хяналт тавьж ажиллаагүй.	7
Хэнтий аймаг Хэрлэн сум Аймгийн ЗДТГ-ын байр 320 тоот	- Үйл ажиллагааны үр дүн, үр ашгийг тооцон дүгнэдэггүй. - Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдалд тавих хяналт хангалтгүй.	7-8
	Дүгнэлт	8
	Зөвлөмж	8-9
	Холбогдох байгууллагын санал:	9-11
	Дүгнэлт	11
	Зөвлөмж	12
	Холбогдох байгууллагын санал:	13

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗЗНДНТУТХ	Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТБОНӨТ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан ТАБ-ын бүрэн эрхийн хүрээнд Монгол улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/15 дугаар “Аудитын сэдэв батлах тухай”, А/28 дугаар “Аудитын төлөвлөгөө батлах тухай” тушаалаар батлагдсан аймаг дахь ТАГ-ын гүйцэтгэх төлөвлөгөөний дагуу хийлээ.

2. Аудитын зорилт:

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх зүйн үндэслэл, үйл ажиллагааны зохицуулалт, үр ашигт гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж дүнг холбогдох байгууллага, албан тушаалтан болон аймгийн ИТХ-д танилцуулахад чиглэгдсэн.

Дээрх зорилгыг хангахын тулд дараах зорилтын хүрээнд аудит хийв. Үүнд:

- Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх зүйн үндэслэл тодорхойлогдсон эсэх
- Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааны гүйцэтгэл хэрхэн хэрэгжиж байгаа эсэх
- Үйл ажиллагааны үр ашгийг тооцож, хяналт тавьсан эсэх

3. Аудитын хамарсан хүрээ:

Аудитад аймгийн орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийг хамруулж, тэдгээрийг үүсгэн байгуулагч, байгуулахтай холбоотой тогтоол шийдвэр, баталсан журам, бүртгэл мэдээлэл, 2018-2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, мэдээ, санхүүгийн тайлан, аймгийн ЗДТГ-ын СТСХэлтэс, орон нутгийн өмчийн газар болон холбогдох бусад байгууллагуудыг хамруулав.

4. Аудитын арга зүй, стандарт мөрдөлт:

Аудитыг гүйцэтгэлийн аудитын удирдамж АДБОУС 300, 3000, 3001-г ашиглан, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмыг баримтлан гүйцэтгэж, Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүн шинжилгээ хийн аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

5. Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашигласан. Үүнд:

- Компаний тухай хууль
- ТБОНӨТХууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- МУ-ын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Бусад холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэр, журам, заавар

6. Хүндрэл бэрхшээл

“Өндөрхаан сүү” болон “Хавтгарын хөгжил” ОНӨААТҮГ-ууд нь үйл ажиллагаа явуулдаггүй, өмнөх онуудад ажиллаж байсан захирал өөрчлөгдсөн тул мэдээлэл авах боломжгүй, холбогдох баримт бичиг, материал байхгүй тул аудитад хамруулаагүй.

7. Ерөнхий мэдээлэл

Аймаг, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор ОНӨҮГ-ын ажиллах журам, дүрмийг баталж бүтэц орон тооны хязгаарыг баталсан ба орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн зорилгыг *орон нутгийн хүн амын нийтийн хэрэгцээг хангах* гэж ерөнхий байдлаар тодорхойлон, төрийн байгууллагын үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгэх, тохижилт үйлчилгээ, хог хаягдлыг цуглуулах, соёлын өвийг хамгаалах, ойн нөөц байгаль хамгаалах нөхөн сэргээх, үйлдвэрлэл эрхлэх, ус түгээх ариутгах дулаан дамжуулах чиглэлээр байгуулагдсан нийт 17 хуулийн этгээд байна.

1. Батширээт сум дундын ой анги ТБАГУТҮГазар
2. Батширээт сум тохижилт ОНӨААТҮГазар
3. Батширээт сумын Хавтгарын хөгжил ОНӨААТҮГазар
4. Баян-Адарга сумын “Адарга” тохижилт ААТҮГазар
5. Монгол хатдын өргөө цогцолбор ашиглалтын өмнөх захиргаа ОНӨААТҮГазар
6. Баянмөнх тохижилт ОНӨААТҮГазар
7. Биндэр сум дундын ой анги ОНӨААТҮГазар
8. Биндэр нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГазар
9. Бор-Өндөр хот тохижилт ОНӨААТҮГазар
10. Хэнтий Шинэс сум дундын ой анги ОНӨААТҮГазар
11. Өмнөдэлгэр нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГазар
12. Жаргалтхаан тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазар
13. Дархан сумын тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазар
14. Өндөрхаан сүү ОНӨААТҮГазар
15. Өндөрхаан тохижилтийн газар ТБАГУТҮГазар
16. Хэнтий аймгийн Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГазар
17. Хэнтий Ус ХХКомпани

Тайлант онуудад орон нутгийн төсөв болон орон нутгийн хөгжлийн сангаас 6 ОНӨААТҮГазарт 4,251.6 сая төгрөгийн санхүүжилт, 5,164.2 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлжээ.

- 2018 онд тайлан гаргасан 11 хуулийн этгээдээс 3
- 2019 онд тайлан гаргасан 12 хуулийн этгээдээс 8
- 2020 онд тайлан гаргасан 13 хуулийн этгээдээс 8 хуулийн этгээдүүд алдагдалтай тайлан гаргасан
- 2018 оноос хойш үйл ажиллагаа явуулаагүй "Х" тайлан гаргасан 3 хуулийн этгээд байна.

НЭГ. Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийг эд хөрөнгийн эрхийн байдлаар хуульд зааснаар ангилан тодорхойлоогүй байна.

1.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийг хуулийн дагуу ангилаагүй.

1.1.1. Аудитад хамрагдсан 15 орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдээс:

- Орон нутгийн тохижилт, үйлчилгээний чиглэлээр 9
- Нийтийн ахуйн үйлчилгээний чиглэлээр 1
- Ойжуулалт, ойн арга хэмжээний чиглэлээр 3
- Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд туслах чиглэлээр 1
- Түүхэн соёлын үнэт өвийг хадгалах, хамгаалах чиглэлээр 1 хуулийн этгээдүүдийг МУЗЗНДНТҮТХуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3¹, ТБОНӨТХуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4² дэх хэсэг, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйл 17.2.8.³ дэх заалтуудыг тус тус үндэслэн аймаг, сумын ИТХ-ын Тэргүүлэгчид болон аймгийн Засаг даргаас байгуулжээ.

1.1.2. Төрийн болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар бий болсон өмч хөрөнгөөр үүсгэн байгуулсан орон нутгийн өмчийн хуулийн этгээдүүдийн хариуцлагын хэлбэрийг ТБОНӨТХуулийн 13 дугаар зүйлд⁴ зааснаар ангилаагүйгээс орон нутгийн төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт, тайлагналт, үр ашгийг тооцоход боломжгүй болжээ.

Шалгагдагч 15 хуулийн этгээдүүдээс 11 хуулийн этгээдийн үүсгэн байгуулсан шийдвэр болон улсын бүртгэлийн хариуцлагын хэлбэр зөрүүтэй, бусад 4 хуулийн этгээдийнх *ИЖаргалтхаан, Өмнөдэлгэр, Биндэр сумдын тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазрууд, Хэнтий Ус ХХКомпани* нийцэж байгаа боловч 15

¹ "орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах;"

² "орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих."

³ "аймгийн байгаль орчны газрын харьяанд сум дундын ойн анги, нийслэлийн байгаль орчны газарт ойн асуудал эрхэлсэн нэгж байгуулж, бүтэц, орон тоо батлан, тэдгээрийн даргыг байгаль орчны газрын даргатай зөвшилцөн томилох, чөлөөлөх."

⁴ Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төр өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээдийг төрийн өмчит хуулийн этгээд гэнэ. Төрийн өмчит хуулийн этгээдийг эд хөрөнгийн эрхийн байдлаар нь дор дурдсанаар ангилна:

1/ төрийн байгууллага, албан газар;

2/ төрийн өмчит үйлдвэрийн газар.

3/төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг.

хуулийн этгээдүүд ОНӨААТҮГазар, ОНӨААТҮҮГазар, ОНТҮГазар, Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар гэх зэргээр эд хөрөнгийн эрхийн байдлыг хууль тогтоомжид нийцүүлэлгүй тодорхойлсон нь нөлөөлжээ.

1.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн үйл ажиллагааны зорилго, зорилтыг тодорхойлолгүй гүйцэтгэх чиглэлээр ажиллах дүрмийг боловсруулж мөрдлөгө болгон ажиллаж байна.

1.2.1. МУЗЗНДНТУТХуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 ж⁵ дэх заалтыг үндэслэн шалгагдагч 15 орон нутгийн өмчит хуулийн этгээдээс аймаг, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор 12 хуулийн этгээдийн дүрмийг, аймгийн ЗД-ын захирамжаар 2 хуулийн этгээдийн дүрмийг тус тус баталж, 1 хуулийн этгээд үлгэрчилсэн дүрэм мөрдөн ажиллаж байна.

1.2.2. Ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх зорилгоор Биндэр, Батширээт, Өмнөдэлгэр “Хэнтий Шинэс” сум дундын ойн ангиудыг Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.8.⁶ дэх заалтыг үндэслэн байгуулсан ч дээрх хуулийн хэрэгжилтийг хангах ЗГ-ын 2012 оны 255 дугаар “Ойн талбай норматив, байршил батлах тухай” тогтоолын хэрэгжилтийг хангалтгүй зохион байгуулж, ой ангиудын үйл ажиллагааны гол баримт болох дүрмийг хууль, тогтоомжийн дагуу ИТХ-аар батлуулаагүй аймгийн Засаг даргын ой анги үүсгэн байгуулсан захирамжаар баталсан нь ТБОНӨТХууль болон дээрх ЗГ-ын тогтоолыг хэрэгжүүлээгүй байгааг анхаарах шаардлагатай.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн үйл ажиллагааны дүрмүүдийг эрх бүхий этгээдүүдээс баталсан ч Жаргалтхаан, Өмнөдэлгэр сумдын нийтлэг үйлчилгээний газар, “Хэнтий Ус” ХХК-ын дүрмүүдэд үйл ажиллагааны зорилго зорилтыг тодорхойлон үйл ажиллагааны чиглэлийг тусгаж өгчээ.

Бусад:

- Батширээт сум дундын ой анги ТБАГУТҮГазар
- Батширээт сум тохижилт ОНӨААТҮГазар
- Баян-Адарга сумын “Адарга” тохижилт ААТҮГазар
- Монгол хатдын өргөө цогцолбор ашиглалтын өмнөх захиргаа ОНӨААТҮГазар
- Баянмөнх тохижилт ОНӨААТҮГазар
- Биндэр сум дундын ой анги ОНӨААТҮГазар
- Биндэр нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГазар
- Бор-Өндөр хот тохижилт ОНӨААТҮГазар

⁵ "орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах;"

⁶ "аймгийн байгаль орчны газрын харьяанд сум дундын ойн анги, нийслэлийн байгаль орчны газарт ойн асуудал эрхэлсэн нэгж байгуулж, бүтэц, орон тоо батлан, тэдгээрийн даргыг байгаль орчны газрын даргатай зөвшилцөн томилох, чөлөөлөх."

- Хэнтий Шинэс сум дундын ой анги ОНӨААТҮГазар
- Дархан сумын тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазар
- Өндөрхаан тохижилтийн газар ТБАГУТҮГазар
- Хэнтий аймгийн Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГазруудын дүрэмд үйл ажиллагааны зорилго зорилтыг тодорхойлолгүй эрхлэн гүйцэтгэх чиглэлийг тусгасан нь хуулийн этгээдүүдийн зорилго зорилт хэрхэн хангагдаж байгаад хяналт тавьж үйл ажиллагааны үр дүн, төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг дүгнэн тооцоход хүндрэл үүсгэж байна.

ХОЁР. Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн зорилго, зорилтын хангалтыг бус эрхлэн гүйцэтгэх чиглэлээр үйл ажиллагааг дүгнэжээ.

2.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд хууль тогтоомж, тогтоол шийдвэр, батлагдсан дүрэм журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

2.1.1. Аймаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал ТБОНӨТХуулийн 77 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн хүн амын нийтийн хэрэгцээг хангах үндсэн зорилгоор орон нутгийн өмчит 14 хуулийн этгээдүүдийг байгуулсан бол аймгийн Засаг дарга Ойн тухай хуулийн 17 дугаар зүйл 17.2.8 дэх заалтын дагуу ойжуулалт, ойн арга хэмжээний чиглэлээр орон нутгийн өмчит 3 хуулийн этгээдүүдийг тус тус байгуулж үйл ажиллагааны дүрмүүдийг баталжээ.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд үүсгэн байгуулагчаас баталсан үйл ажиллагааны дүрмийн дагуу дотоод журмаа хамт олны хуралдаанаар хэлэлцэн баталгаажуулж үйл ажиллагаандаа мөрдөж байна.

2.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн зорилго, зорилтыг үйл ажиллагааны дүрэмд тодорхойлоогүй тул хангагдан ажилласан гэж үзэх боломжгүй.

2.2.1. Шалгагдагч орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нь холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг мөрдөж батлагдсан дүрмийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлээ хэрэгжүүлэн ажиллаж байгаа ч зорилго зорилтоо хангаж, холбогдох хуулиар нарийвчлан зохицуулсан заалтын хэрэгжилтийг ханган ажилладаггүй.

Тухайлбал:

ТБОНӨТ хуулийн 21/1 дүгээр зүйлийн 21/1.1 дэх заалтын дагуу байгууллагын зорилго зорилт, түүнийг хэрэгжүүлэх талаар санал төслийг аймгийн орон нутгийн өмчийн газарт хүргүүлдэггүй.

Орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд дүрмийнхээ дагуу үйл ажиллагааны гэрээ байгуулдаг ч ТБОНӨТ хуулийн 21/1 дүгээр зүйлийн 21/1.8

дахь хэсэгт заасны дагуу зорилго зорилтын саналтай харьцуулан дүгнэж болох ижил үзүүлэлттэй байх шаардлагатай мэдээллийг агуулаагүй.

Орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн удирдлагууд хуулийн хүрээнд томилогдсон ч Төсвийн тухай хуулийн 40.1, 40.2 дахь заалтуудын хүрээнд дээд шатныхаа төсвийн захирагчтай тухайн оны санхүүжилтийн чиглэлээр үр дүнгийн гэрээ байгуулж хөрөнгө оруулалтыг зорилго зорилт, эрхлэх үйл ажиллагааныхаа хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, хүрэх үр дүн, түүнийг дүгнэх талаар тусгаагүй байна.

Шалгагдагч орон нутгийн өмчит 15 хуулийн этгээдүүдийн 13 хуулийн этгээдийн үйл ажиллагааны дүрэмд зорилго зорилтыг тодорхойлж чиг үүргийг нарийвчлан тусгаж өгөөгүйгээс дээрх зөрчил үүссэн байна.

ГУРАВ. Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн үйл ажиллагааны үр ашгийг тооцож, хяналт тавьж ажиллаагүй.

3.1. Үйл ажиллагааны үр дүн, үр ашгийг тооцон дүгнэдэггүй.

3.1.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн үйл ажиллагааны дүрэмд үр дүн, үр ашгийн гүйцэтгэлийг хэрхэн тооцож цаашид авах арга хэмжээг нарийвчлан тусгалгүй орхигдуулж тухайн жилийн санхүүгийн тайлан гаргаж баталгаажуулах зохицуулалт тусгаснаас хэтрээгүй байна.

Санхүүгийн тайланд тусгагдсан орлогын талаар авч үзвэл:

Орон нутгийн төсөв болон орон нутгийн хөгжлийн сангаас 100 хувь санхүүжилт авч байгаа:

- Өндөрхаан хот тохижилтын газар ОНӨААТҮГазар

Орон нутгийн төсвөөс санхүүжилт авч байгаа:

- Батширээт сум дундын ой анги ТБАГУТҮГазар
- Биндэр сум дундын ой анги ОНӨААТҮГазар
- Бор-Өндөр хот тохижилт ОНӨААТҮГазар
- Хэнтий Шинэс сум дундын ой анги ОНӨААТҮГазар
- Хэнтий аймгийн Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ

ОНТөсөв болон ОНХСангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг хүлээн авч ашиглаж байгаа:

- Монгол хатдын өргөө цогцолбор ашиглалтын өмнөх захиргаа ОНӨААТҮГазар
- Бор-Өндөр хот тохижилт ОНӨААТҮГазар
- Дархан сумын тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазар
- Өндөрхаан тохижилтийн газар ТБАГУТҮГазар
- Хэнтий Ус ХХКомпани

Төсвөөс санхүүжилт аваагүй өөрийн орлогоор үйл ажиллагаа явуулж байгаа:

- Батширээт сум тохижилт ОНӨААТҮГазар

- Биндэр сум дундын ой анги ОНӨААТҮГазар
- Өмнөдэлгэр нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГазар
- Жаргалтхаан тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазар
- Хэнтий Ус ХХКомпани

Тайлант онуудад үйл ажиллагаа явуулж байгаа 13 аж ахуйн нэгжүүдээс алдагдалтай ажиллаж байгаа:

- Батширээт сум дундын ой анги ТБАГУТҮГазар
- Батширээт сум тохижилт ОНӨААТҮГазар
- Монгол хатдын өргөө цогцолбор ашиглалтын өмнөх захиргаа ОНӨААТҮГазар
- Биндэр сум дундын ой анги ОНӨААТҮГазар
- Биндэр нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГазар
- Бор-Өндөр хот тохижилт ОНӨААТҮГазар
- Хэнтий Шинэс сум дундын ой анги ОНӨААТҮГазар
- Хэнтий аймгийн Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГазар

Үйл ажиллагаа явуулахгүй байгаа:

- Батширээт сумын Хавтгарын хөгжил ОНӨААТҮГазар
- Баянмөнх тохижилт ОНӨААТҮГазар
- Өндөрхаан сүү ОНӨААТҮГазрууд байна.

Дээрхээс авч үзэхэд орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд зорилго зорилтынхоо хэрэгжилт, үр ашиг, өмч ашиглалтыг сайжруулан, орон нутгийн төсөв, өмчийг хуулийн дагуу арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж ажиллах.

Орон нутгийн өмчийн газраас тавих хяналтыг сайжруулан, үйл ажиллагааны үр дүнг үнэлж, алдагдалтай ажиллаж байгаа болон үйл ажиллагаа явуулдаггүй орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийг өөрчлөх асуудлыг хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хүрээнд боловсруулж аймаг, сумын ИТХурал болон аймгийн Засаг даргын шийдвэрүүдээр тодорхой арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй.

3.1.2. Аймаг сумын Засаг дарга МУЗЗНДНТУТХуулийн 29 дүгээр зүйл 29.1.2.а дахь хэсэгт заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэн ажиллаж орон нутгийн өмчийн талаарх бодлого, тухайн шатны ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулсан талаар тайлан дүгнэлтийг гаргаагүй.

3.1.3. Аймаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал ТБОНӨТХуулийн 77 дугаар зүйлд 77.2 дахь заалтын бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулсан шийдвэртээ тухайн хуулийн этгээдийг бодлогоор хангаж хяналт тавьж ажиллахыг аймаг, сумын Засаг даргад үүрэгжүүлсэн боловч жил бүр орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгөөгүй байна.

3.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдалд тавих хяналт хангалтгүй.

3.2.1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 52 дугаар “Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, дүгнэх журам батлах тухай” тогтоолоор орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн өмчийн ашиглалт хамгаалалт, зарцуулалтыг хянах зорилгоор тусгайлан журам гаргаж хэрэгжилтийг Орон нутгийн өмчийн газар зохион байгуулан ажиллаж байгаа ч 2018-2020 онуудад шалгагдагч орон нутгийн өмчит 17 хуулийн этгээдээс дараах байдлаар “орон нутгийн өмч эзэмшүүлэх гэрээ” байгуулан ажилласан байна:

Д/д	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн нэр	2018 онд гэрээ		2018 онд гэрээ		2020 онд гэрээ	
		Байгуулсан	Дүгнэсэн	Байгуулсан	Дүгнэсэн	Байгуулсан	Дүгнэсэн
1	Хэнтий Нийтлэг үйлчилгээ	+	+	+	-	+	=
2	Монгол хатдын өргөө цогцолбор	-	-	-	-	+	=
3	Баян-Адарга сумын “Адарга” тохижилт	2020 онд үүсгэн байгуулагдсан					
4	Баянмөнх тохижилт	+	+	-	-	-	=
5	Жаргалтхаан тохижилт үйлчилгээ	+	+	+	+	+	=
6	Хэнтий аймгийн Дархан сумын тохижилт үйлчилгээ	2020 онд үүсгэн байгуулагдсан					
7	Бор-Өндөр хот тохижилт	+	+	+	+	+	=
8	Өндөрхаан хот тохижилт газар	+	+	+	-	+	=
9	Өмнөдэлгэр нийтлэг үйлчилгээ	-	-	-	-	-	=
10	Хэнтий Шинс сум дундын ойн анги	+	+	+	-	+	=
11	Биндэр нийтлэг үйлчилгээ	-	-	+	+	+	=
12	Биндэр сумын Сум дундын Ойн анги	+	+	+	+	+	=
13	Батширээт сумын Сум дундын ойн анги	+	+	+	+	+	=

14	Батширээт сум тохижит	-	-	-	-	-	=
15	Батширээт сум Хавтгарын хөгжил	-	-	-	-	-	=
16	Хэнтий Ус ХХКомпани	+	+	+	-	+	=
17	Өндөрхаан сүү	-	-	-	-	-	=
Дүн		9	9	9	5	10	=

Дээрхээс харахад орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн 50 хувьтай өмч эзэмшүүлэх гэрээ байгуулан хэрэгжилтийг дүгнэн ажиллаж байгаа нь “Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, дүгнэх журам”-ыг Орон нутгийн өмчийн газар хэрэгжүүлэн ажиллахгүй байна.

ОНӨААТҮГ-ын жилийн эцсийн санхүүгийн тайланг ТЕЗ-ийн тайланд нэгтгэгддэг байдлыг авч үзвэл нэг байгууллага 2 тайлан гаргаж нэгтгүүлж байна. Үүнд: Өмнөдэлгэр сум дахь Хэнтий Шинэс ой анги, Батширээт сум дундын ой анги, Биндэр сум дундын ой анги, Бор-Өндөр хот тохижилт

Дээрх байдлаас харахад төсөвт байгууллага, ОНӨААТҮГ гэдэг стаус нь тодорхойгүй байдлаас болж байгаа тул цаашид эрх зүйн байдлыг нь хуульд нийцүүлэн санхүүгийн тайланг үнэн зөв нэгтгэх шаардлагатай байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Аймаг, сумын ИТХ, аймгийн ЗД-аас байгуулсан орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13 дугаар зүйлд зааснаар эд хөрөнгийн эрхийн байдлаар хуульд нийцүүлэн ангилаагүй.
2. Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн үйл ажиллагааны дүрэм нь ААТҮГ-т нийцээгүй тул хуулийн этгээдүүдийн үйл ажиллагаа үр ашигийг тооцдоггүй хангалтгүй.
3. Орон нутгийн өмчийн газар нь орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн зорилго зорилтын хэрэгжилт, үр ашиг, өмч эзэмшүүлэлтэнд хяналт тавих ажлыг хангалтгүй зохион байгуулсан.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аймаг, сумын ИТХ-д

1. Үүсгэн байгуулсан орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн эрхийн байдлыг хуульд нийцүүлэн, үйл ажиллагааны дүрэмд зорилго зорилтыг тодорхойлон баталж, үйл ажиллагааны үр дүн, үр ашгийг зорилго зорилттой уялдуулан дүгнэж чиглэл өгч ажиллах.

Аймаг, сумын Засаг дарга-д

2. Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудад заасан орон нутгийн өмчийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийн хэрэгжилтийг зохион байгуулж, тухайн шатны ИТХ-аас орон нутгийн өмчит хуулийн этгээдийг бодлогоор хангаж, хяналт тавин ажиллах үүрэг болгосон арга хэмжээг чанартай гүйцэтгэж хуулийн дагуу тайлагнан ажиллах.

Орон нутгийн өмчийн газар-т

3. Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн эрх зүйн үндэс, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнд холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрхэн хэрэгжүүлэх, гүйцэтгэхэд арга зүйгээр хангаж, хяналт тавьж орон нутгийн шийдвэр гаргагч нарыг нөхцөл байдлын бодит мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн захирлуудад

4. Үйл ажиллагааны зорилго, зорилтыг хангах төлөвлөгөө хөтөлбөр гарган батлуулж, тайлангаа холбогдох эрх бүхий этгээдэд танилцуулж байх.
5. Дүрэмд заасан эрхлэх үйл ажиллагааны төрлийг зорилго зорилттой уялдуулан шинэчлэх.
6. Эрхлэх үйл ажиллагааны чиглэлээр бус дүрмээр батлагдсан зорилго зорилтын хүрээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон өмч хөрөнгийг эзэмшин хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, үр ашгийг илэрхийлсэн гүйцэтгэлээр үйл ажиллагаагаа эрхлэн хэрэгжүүлэх.

Аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжилтийг 2022 оны 3 дугаар сарын 15-ны дотор Төрийн аудитын газарт албан бичгээр ирүүлнэ үү.



**ХЭНТИЙ АЙМАГ
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗАР**

23119 Чингис хот, Хэрлэн сум,
Утас: (976)-70-56-38-83, E-mail: khe_onug@yahoo.com

2021.06.22 № 275
танай 2021.06.22-ны № 509 -т

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

“Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх зүйн
үндэслэл, үйл ажиллагааны зохицуулалт, үр ашиг”-т хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.
Тайлангийн төсөлд санал хүсэлтгүй болно.

ДАРГА

Л.БАТСАЙХАН





ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 06 дугаар сарын 23

Дугаар А/07

Чингис хот

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар “Журам батлах тухай” тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 9 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх зүйн үндэслэл, үйл ажиллагааны зохицуулалт, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, Орон нутгийн өмчийн газар болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдэд хүргүүлж, audit.mn сайтад бүрэн эхээр нь байршуулсугай.
3. Аудитын зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор /Ч.Баярцолмон/-д даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР